

## **АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРААС 2013 ОНД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

Авлигатай тэмцэх газар нь 2013 онд авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэхэд иргэний нийгмийн байгууллага болон олон нийтийг татан оролцуулах, өсвөр үе, залуучуудад шударга ёсны үзлийг зөв төлөвшүүлэх, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, хяналт, шалгалтыг хууль тогтоомжийн шаардлагад бүрэн нийцүүлэн сайжруулах, үр дүнд хүргэх, байгууллага, албан хаагчийн аюулгүй байдал, дотоодын хяналт шалгалтын үйл ажиллагааг төгөлдөршүүлэх, олон улсын туршлагад тулгуурлан судалгаа шинжилгээний ажлын аргачлалыг улам боловсронгуй болгох, хууль дээдлэх зарчмыг эрхэмлэж, авлигын гэмт хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалтын үр дүнг нэмэгдүүлэх зорилт дэвшүүлэн, хуулиар хүлээсэн үндсэн чиг үүрэг, зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд хэлтэс, албадын хамтын ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, албан хаагчид, ажилтнуудын ажлын үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллалаа.

### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын ажлын чиглэлээр**

Тайлангийн хугацаанд авлигатай тэмцэх үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, авлигын гэмт хэрэгтэй тэмцэх болон Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж, удирдах арга хэмжээний хүрээнд Газрын даргын зөвлөлийн хурлыг 6 удаа зохион байгуулж, уг хурлаар ажилтнуудад нийтийн орон сууц худалдан авахад туслалцаа үзүүлэх, орон сууцны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх журам батлах тухай, албан хаагчдад орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай, албаны шалгалтын дүнгийн талаар, полиграфын аппарат худалдан авах эсэх талаар зэрэг авлигатай тэмцэх үйл ажиллагааны бодлогын шинж чанартай асуудлуудыг, байгууллагын хүний нөөцийн болон хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх бодлого чиглэлийн талаарх асуудлуудыг хэлэлцэн тодорхой шийдвэр гаргаж ажилласан.

Авлигатай тэмцэх газрын Удирдлагын шуурхай зөвлөлгөөнийг 42 удаа зохион байгуулж, өмнөх 7 хоногийн шуурхай зөвлөлгөөний үүргийн биелэлт, хэлтэс, албадын 7 хоногт хийсэн ажлын мэдээлэл, цаг үеийн асуудал зэргийг хэлэлцэж, байгууллагын үйл ажиллагааг өдөр тутмын шуурхай удирдлагаар хангаж ажилласан.

Авлигын эсрэг хуульд заасан нэгдмэл удирдлагатай байх зарчмыг хэрэгжүүлэх, хэлтэс, алба, ажилтнуудын нягт хамтын ажиллагааг бэхжүүлэх

зорилгоор тус газраас зохион байгуулж буй удирдлага, зохион байгуулалтын болон авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар газрын нийт албан хаагчдад мэдээлэх, цаг үеийн шаардлагатай мэдээ, мэдээллийг шуурхай хүргэх, албан хаагчдад сургалт, танин мэдэхүйн чиглэлээр мэдээлэл өгөх арга хэмжээг 14 хоног тутам зохион байгуулж ажилласан.

Авлигын эсрэг Үндэсний стратеги боловсруулах ажлын хүрээнд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэд байгуулагдсан ажлын хэсэг Монгол Улсын Авлигын эсрэг үндэсний стратеги боловсруулах ажлыг санаачлан эхлүүлж эхний хувилбарыг бэлэн болгоод байгаа бөгөөд УИХ-ын 2013 оны намрын чуулганд өргөн барих төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тус стратегийг эцэслэн боловсруулах болон түүнийг дагалдан гарах төлөвлөгөөг боловсруулах зорилго бүхий илүү өргөн хүрээг хамарсан ажлын хэсэг байгуулах Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын захирамжийн төслийг бэлтгэн хүргүүлсэн бөгөөд тус газар уг ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж байна.

Байгууллагын албан хаагчдын хууль зүйн баталгааг хангах чиглэлийн хүрээнд албан хаагчдын 2013 оны үнэмлэхийг шинэчлэх арга хэмжээ авсан бөгөөд байгууллагын нууцлалын баталгааны хуудсыг шинээр томилогдсон албан хаагчдаас гаргуулах арга хэмжээг авч ажилласан ба шинээр ажилд томилогдсон албан хаагчид болон эрүүгийн дугаар хэргүүдэд шинжээчээр ажилласан болон байгууллагын үйл ажиллагаанд хамтран оролцсон иргэдээс Монгол Улсын Байгууллагын нууцын тухай хууль, Авлигатай тэмцэх газрын даргын 2012 оны н/01 дугаар тушаалаар батлагдсан “Авлигатай тэмцэх газрын нууцын тухай журам”-ыг тус тус удирдлага болгон Байгууллагын нууцын тухай баталгаа гаргуулж авсан.

Тайлангийн хугацаанд авлигатай тэмцэх ажлыг зохион байгуулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх зорилгоор **10013** албан бичгийг албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд хүргүүлж, тус газарт ирсэн **11705** албан бичгийг хүлээн авч Албан хэрэг хөтлөх журмын дагуу бүртгэлд авч, холбогдох арга хэмжээг авах, үйл ажиллагаандаа ашиглах, холбогдох хариуг хүргүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан.

Тайлангийн хугацаанд Авлигын эсрэг хууль, УИХ-ын тогтоолыг удирдлага болгон Авлигатай тэмцэх газрын 7 албан хаагчид ахлах комиссар, 20 албан хаагчид комиссар, 4 албан хаагчид дэд комиссар зэрэг дэв олгуулах болон шинээр томилогдсон албан хаагчдыг Авлигын эсрэг хуульд заасны дагуу тангараг өргүүлэх ажлыг тухай бүрт нь зохион байгуулж, шинээр томилогдсон албан хаагчдад

байгууллагын Хөдөлмөрийн дотоод журам болон бусад холбогдох дүрэм, журам, заавруудыг танилцуулан судлуулж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах талаар зөвлөмж өгч ажилласан.

Авлигатай тэмцэх газрын хүний нөөцийн чадавхийг сайжруулах ажлын хүрээнд 14 албан хаагчийг худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрх бүхий ажилтны сертификатыг олгох сургалтад, 9 албан хаагчийг Мөнгө угаахын эсрэг олон улсын байгууллагаас зохион байгуулсан Хууль сахиулах байгууллагуудын чадавхийг дээшлүүлэх сургалтад, 2 албан хаагчийг ОХУ-ын Москва хотноо зохион байгуулагдсан “Мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах, дүн шинжилгээний арга тусгай технологи-интернэт тагнуул” сэдэвт сургалтад, 1 албан хаагчийг БНСУ-ын Сөүл хотноо зохион байгуулагдсан Олон улсын авлигатай тэмцэх салбарын мэргэжилтнүүдэд зориулсан 14 хоногийн сургалтад, 3 албан хаагчийг БНХАУ-д зохион байгуулагдсан Авлигын эсрэг олон улсын байгууллагуудын холбооны 5 дугаар уулзалт, сургалтад хамруулах ажлыг зохион байгуулснаас гадна Санхүүгийн анхан шатны мэдлэг олгох сургалтад 40 албан хаагчийг хамруулав. Мөн Дэлхийн банк, НҮБ-ын Мансууруулах бодис, хар тамхитай тэмцэх газрын хамтарсан төсөл болох Хулгайлагдсан хөрөнгийг буцаах санаачилгатай хамтран ажиллах хүрээнд Улаанбаатар хотноо зохиогдсон “Санхүүгийн гэмт хэргийг мөрдөн шалгах”, “Эрх зүйн харилцан туслалцаа хүссэн захидал боловсруулах” сэдэвт сургалтыг бие даан зохион байгуулж тус газрын 25 бусад хууль сахиулах байгууллагуудын 35 албан хаагч, нийт 60 албан хаагчийг уг сургалтад хамруулан ажилласан. Мөн нийт 20 албан хаагчид гүйцэтгэх ажлын анхан шатны мэдлэг олгох 45 хоногийн 117 цагийн сургалтыг зохион байгуулсан.

Албан хаагчдын албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангах зорилгоор нийслэлийн Чингэлтэй дүүргийн Спорт цогцолбортой байгуулсан гэрээний дагуу 7 хоногийн лхагва гараг бүр ажилтан, албан хаагчдын биеийн тамирын болон албаны бэлтгэл сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 900 шахам албан хаагчийг хамруулсны зэрэгцээ 2013 оны 4, 5 дугаар сард Үндэсний статистикийн хорооноос зохион байгуулсан УИХ-аас байгуулагддаг байгууллагуудын дунд зохиодог уламжлалт тэмцээнд спортын 6 төрлийн тэмцээнд тамирчдын бэлтгэлийг хангуулан амжилттай оролцож 1 алт, 2 мөнгөн медаль хүртэж, багийн дүнгээр 5 дугаар байр эзэлсэн амжилт үзүүлсэн.

Тайлангийн хугацаанд газрын албан хаагчдаас 52 өргөдөл хүлээн авснаас 52 албан хаагчийн өргөдлийг шийдвэрлэж, холбогдох хариуг өгч ажилласан.

Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, орон сууцны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд онцгой анхаарч “Ажилтнуудад нийтийн орон сууц худалдан авахад туслалцаа үзүүлэх, орон сууцны нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх журам”-ыг шинээр боловсруулан батлуулж, энэ журмын хүрээнд нийт 48 албан хаагчид нийт 2.0 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.

Хяналт шалгалтын ажлын чиглэлээр сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан 18 хүнд холбогдох 17 материал, захиргааны зөрчил гаргасан 4 хүнд холбогдох 5 материалд албаны шалгалтыг явуулж, боловсон хүчний судалгаагаар 20 хүнд холбогдох 20 материалыг танилцуулж нийтдээ 42 хүнд холбогдох 42 материалд холбогдох шалгалтыг явуулсан байна.

Сахилгын болон ёс зүйн зөрчил гаргасан 18 хүнд холбогдох 17 материалаас 7 хүнд холбогдох 7 материалыг байгууллагын Удирдлагын болон Ёс зүйн зөвлөлөөр хэлэлцүүлж ажлаас халагдсан шийтгэл хүлээсэн 1 албан хаагчийн 1 материал, ажлаас хүсэлтээр халагдсан 2 албан хаагчийн 2 материал, сануулгын шийтгэл хүлээсэн 1 албан хаагчийн 1 материал, хурлын тэмдэглэлээр анхааруулах авсан 1 албан хаагчийн 1 материал, 2 албан хаагчийн 2 материалыг арга хэмжээ авалгүй хуралдаанд танилцуулсан байна.

Нийт шалгасан материалыг ёс зүй, сахилгын зөрчлийн төрөл, хэлбэрээр нь:

| №           | Шалгасан зөрчлийн төрөл   | 2013 онд  |           |
|-------------|---|-----------|-----------|
|             |   | зөрчил    | хүн       |
| 1.          | Албан үүрэгт ажилдаа хариуцлагагүй, хайнга хандаж ёс зүйн зөрчил гаргасан гэх үндэслэлээр                             | 5         | 6         |
| 2.          | Хууль тогтоомж, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг зөрчиж, ажлын алдаа дутагдал буюу зөрчил гаргасан гэх үндэслэлээр | 9         | 9         |
| 3.          | Ажил тасалсан, чөлөө зөвшөөрөл хэтрүүлсэн гэх үндэслэлээр   | 2         | 2         |
| 4.          | Бусад зөрчлүүд  | 1         | 1         |
| <b>Бүгд</b> |   | <b>17</b> | <b>18</b> |

Тайлангийн хугацаанд байгууллагын цахим хуудасны агуулгыг байнга шинэчлэх, засварлах ажлыг хийсэн ба өгөгдлийн санг сард нэг удаа архивлан авч, хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Байгууллагын вэб сайт 2007 оны 8 дугаар сараас ашиглалтад орсон цагаас хойш өнөөдрийг хүртэл давхардсан тоогоор 319612 зочин, сард дунджаар давхардсан тоогоор 4205 зочин орж манай байгууллагын талаарх мэдээллийг авч, санал сэтгэгдэл, өргөдөл гомдол, хүсэлтээ бидэнд илгээж байна. Байгууллагын <http://www.iaac.mn> цахим мэдээллийн хуудсанд хандсан зочдын тоог 2012 оны эхний хагас жилийн мөн үетэй харьцуулбал 30,7 хувиар өссөн бөгөөд энэ нь ХАСХОМ-ийг цахим хэлбэрээр авсантай холбоотой юм.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэлийн систем” програм хангамжийг ашиглалтад оруулахад шаардлагатай байсан интернэт сүлжээ, <https://meduuleg.iaac.mn> дэд домэйн нэр, SSL сертификат зэргийг үүсгэж, шаардлагатай тохиргоонуудыг хийж ажилласан.

ХАСХОМ-ийг цахим хэлбэрээр авах ажилтай холбогдуулж байгууллагын 71 албан хаагчид албаны мэйл хаяг нээн өгч, хэрхэн ашиглах болон ХАСХОМ гаргаж өгөхөд нь заавар зөвлөгөө өгч ажилласан.

Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтэс, “Ай-Эн-Ай” ХХК-тай хамтран Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн Гомдлын бүртгэлийн програмыг Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажлын хэрэгцээнд нэвтрүүлсэн. Энэ ажлын хүрээнд хэрхэн програмд нэвтрэх, ашиглах талаар Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтнуудад заавар зөвлөгөө өгч ажиллав.

2013 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр Газрын даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг вэб сайтыг шинэчлэхээр хэлтэс, албадаас санал авч загвар, бүтцийг боловсруулан 12 дугаар сарын 25-нд шинэ веб сайтыг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Байгууллагын архивт Тамгын хэлтсээс 2012 оны 28 хадгаламжийн нэгж, Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс 2007-2012 оны 200 хадгаламжийн нэгж, Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн 2009-2011 оны 15 хадгаламжийн нэгж, бүгд 243 баримт бичгүүдийг татаж авч цэгцлэх ажлыг хийж байна.

Гадаад арга хэмжээ, хамтын үйл ажиллагааны хүрээнд манай газар гадаад орны ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагууд, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг улам эрчимжүүлэх зорилтоо хэрэгжүүлэн ажилласан.

Олон Улсын Авлигын эсрэг академитай харилцаагаа гүнзгийрүүлж, Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан нь цаашид албан хаагчдын мэдлэг чадварыг

нэмэгдүүлэхээр олон төрлийн сургалтанд хамруулах, судалгаа шинэжилгээний чиглэлд харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллах чухал алхам болсон.

Мөн Австри Улсын Олон улсын Авлигын эсрэг академийн дарга Мартин Кроитнерын Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэгийн сайд нарын 7 дугаар бага хуралд оролцох болон тус газрын үйл ажиллагаатай танилцах уулзалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг төлөвлөгөөний дагуу хангаж ажилласан.

Энэ ажлын хүрээнд байгууллагын гүйцэтгэх ажлын хүчин чадавхийг хангах чиглэлээр гадаад улсын компаниудын төлөөлөгчидтэй худалдан авалтын гэрээг зөвшилцөн бэлэн болгож худалдан авах ажиллагааг эрхэлж ажилласан.

Тайлангийн хугацаанд байгууллагын албан хаагчдын мэргэшил, чадавхийг бэхжүүлэх чиглэлд албан хаагчдыг Австри улсын Вена хотод Олон Улсын Авлигын эсрэг академийн зуны сургалт, БНСУ-д Авлигын эсрэг Иргэний эрхийн хорооноос зохион байгуулсан авлигатай тэмцэх чиглэлд судалгаа хийдэг мэргэжилтнүүдийн сургалт, БНХАУ-ын Жинан хотод Авлигын эсрэг олон улсын байгууллагуудын холбооны 5 дугаар сургалт, ОХУ-ын Москва хотод Евроазийн мөнгө угаахтай тэмцэх бүлгийн дэргэдэх Олон улсын санхүүгийн хяналт, сургалт арга зүйн төвөөс зохион байгуулсан “Мөнгө угаах гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах, дүн шинжилгээний арга тусгай технологи-интернет тагнуул” сэдэвт сургалтад тус тус хамруулсан.

2013 онд батлагдсан төсвийн хуваарийн дагуу 7 тэрбум 916 сая 600 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилт 2 тэрбум 984 сая төгрөгийн санхүүжилтийг авч зардлын ангиллын дагуу зарцуулсан байна.

Зардлыг төрлөөр нь авч үзвэл 2436.8 сая төгрөг нь цалин хөлс, унаа хоолны хөнгөлөлт 91.4 сая төгрөг, 61.6 сая төгрөг нь тогтмол зардал / гэрэл, цахилгаан цэвэр бохир ус, байрны түрээс/, 56.4 сая төгрөг нь тээвэр шатахуун, 85.2 сая төгрөг нь дотоод томилолт, 51.5 сая төгрөг нь гадаад томилолт, 23.6 сая төгрөг нь бичиг хэрэг, 49.0 сая төгрөг нь сургалт семинар, 62.4 сая төгрөг нь шуудан холбоо, 14.5 сая төгрөг нь гадаад зочин, бэлэг дурсгал, 96.0 сая төгрөг нь мэдээлэл, сурталчилгаа, 80.6 сая төгрөг нь төлбөр хураамж, 34.1 сая төгрөг нь нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, шагнал, урамшуулал, 10.2 сая төгрөг нь тээврийн хэрэгсэл, жолооч, автомшины даатгал, 3.3 сая төгрөг нь ном хэвлэл, 90.5 сая төгрөг нь эд хогшил, жижиг эд аж ахуй зэрэгт тус тус зарцуулсан байна.

Улсын Их Хурал, Сангийн яаманд тус газрын хэлтэс, албадаас ирүүлсэн хөтөлбөрт ажлын хүрээнд 2014 оны урсгал зардалд 8987,8 сая төгрөг, хөрөнгө оруулалтын төсвийн төсөлд 3643,0 сая төгрөгөөр саналыг боловсруулан хүргүүлэв.

2014 оны хөрөнгө оруулалт болон урсгал төсвийн саналыг боловруулан Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Монгол Улсын Их Хуралд өргөн барьж 14,819,5 сая төгрөгийг батлуулсан байна.

2014 оны урсгал төсөв болон хөрөнгө оруулалтын төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулж, Газрын даргаар батлуулан Сангийн яаманд хүргүүлэв.

2012 оны жилийн эцэст хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэртэй 6,4 тэрбум, 2013 оны эхний хагас жилд хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэртэй 8,3 тэрбум төгрөгийн нэгтгэсэн тэнцлийг цаг хугацаанд нь СТОУС болон УСННБОУСтандартын дагуу гаргаж, Нягтлан бодох хуулийн дагуу бүртгэлийг хөтөлж, холбогдох мэргэжлийн байгуулага Төрийн өмчийн хороо, Үндэсний аудитын газраар баталгаажуулан Сангийн яамны Төрийн сангийн газрын нэгдсэн тайланд хүргүүлж ажилласан.

Тайлант хугацаанд давхардсан тоогоор гадаад томилолтоор 83 хоног ажиллаад ирсэн 18 албан хаагчтай 74,5 сая төгрөг, орон нутагт давхардсан тоогоор 1434 хоног ажиллаад ирсэн 224 албан хаагчтай 85,9 сая төгрөгийн зардлын тооцоо хийсэн.

Батлагдсан төсвийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу 2013 оны худалдан авах ажиллагааны ерөнхий тайланг маягт 1, 2, 3 дагуу бэлтгэн гаргасан.

2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж Сангийн яаманд хүргүүлсэн.

Санхүүгийн бусад мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж, холбогдох байгууллагуудад өгч баталгаажуулан, эд, аж ахуйн дотоодын шилжилт хөдөлгөөнийг тухай бүрт нь шилжүүлэн картжуулж, албан хаагчдад шаардлагатай бичиг хэрэг, аж ахуй, хангамжийн материалыг нөөцлөн бэлтгэж, хангалт, үйлчилгээг тогтмол хийж байна.

Хангалт, үйлчилгээний чиглэлээр санхүү аж ахуйн албаны ажилтан, албан хаагчид үл хөдлөх болон эргэлтийн хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, ашиглалт, авто болон бусад албан техник хэрэгслийн хангалт, засвар үйлчилгээ, хуваарилалтыг зохих ёсоор гүйцэтгэх, албан хаагчдын ажиллах тав тухтай орчныг төрийн албаны стандартад нийцүүлэн ажиллах зэргээр 2013 онд төлөвлөгдсөн үйл ажиллагааны зорилтуудаа сайн биелүүлэн ажилласан.

Мөн байгууллагын албан хаагчдын хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэн ажиллах нөхцөл, бололцоог хангах зорилгоор байгууллагын 36 өрөө бүхий 1458 кв м А байрны их засварыг тендерт шалгарсан “Баянсүндэрэл” ХХК-аар 2013 оны 6, 7 дугаар сард гүйцэтгүүлж, сайн дүнтэй хүлээн авсан.

Автомашинь зогсоол, хурлын заалны зориулалттай цайны газар, тусгай бэлтгэлийн өрөө, агуулах зэргийг давхар шийдсэн 1136 кв м 2 давхар барилгын зураг, төслийг хийлгэн зохих зөвшөөрлүүдийг гаргуулан авч 2013 оны 9 дүгээр сард барьж эхэлсэн бөгөөд энэ ондоо багтаан ашиглалтад оруулж байна.

Мөн байгууллагын Б байрны барилгын дутуу хийгдсэн ажлуудыг зохих газарт нь шаардлага хүргүүлэн хийлгэж, бүрэн дуусгасан.

2013 оны өвөлжилтийн бэлтгэлийг хангуулах тусгай төлөвлөгөө гарган ажилласны үр дүнд өвөлжилтийн байдал хэвийн байна.

### **Хоёр. Авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр**

Тайлангийн хугацаанд соён гэгээрүүлэх чиглэлээр аль болох олон талын хамтын оролцоотойгоор нийгмийн тодорхой зорилтот бүлгүүдэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах явдал нь бидний нэн тэргүүний зорилт байх болно гэж тодорхойлсон.

Энэ оны хувьд шударга ёсыг бага наснаас нь төлөвшүүлэх нь зүйтэй гэж үзсэн бөгөөд гол зорилтот бүлгийнхээ нэгийг бага болон өсвөр насны хүүхдүүд гэж тодорхойлон, эхний хагас жилд эдгээр насны бүлгийн хүүхдүүдэд чиглэсэн ажлуудыг хийж эхлүүлсэн. Хүүхэд багачуудад шударга ёсны зан үйл төлөвшүүлэх зорилгоор АНУ-ын Азийн сангийн дэмжлэгтэйгээр хэвлүүлсэн “Шударга мазаалайнууд”, “Найзын яриа” номд дурдсан утга санаа, агуулгыг түгээн дэлгэрүүлэхээр “Зуны даалгавар” арга хэмжээг зохион байгуулсан.



21 аймгийн Засаг даргын Тамгын газрын болон ИТХ-ын Ажлын албаны авлигын эсрэг үйл ажиллагаа хариуцсан эрх бүхий албан тушаалтнуудад зориулсан “Эрх бүхий албан тушаалтан Танаа” гарын авлагыг боловсруулж, тэдэнд авлигын эсрэг хууль тогтоомжийг өөрийн байгууллагадаа хэрэгжүүлэн ажиллахад нь арга зүйн туслалцаа үзүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хөтөч болох зорилгоор бэлтгэсэн.

Авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Авлигатай тэмцэх газрын бүрэн эрх, чиг үүргийн талаар тодорхой ойлголт өгөх зорилгоор “Монгол Улсын Их Хурлын гишүүн Танаа” гарын авлагыг боловсруулж, “Засаглал, ил тод байдлыг дэмжих төсөл”-ийн дэмжлэгтэйгээр хэвлүүлсэн.

Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдын хувьд шударга байдлын түвшиний ерөнхий үнэлгээ 2008, 2010, 2012 онуудад хийсэн судалгааны дүнгээр жил ирэх тутам буурч байгаа байдал нь ёс зүй, ёс суртахуун, зан төлвийн хувьд шударга бус байдалтай эвлэрэх, түүнд дасан зохицох, төлөвших хандлагатай байна хэмээн үзэж ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд ёс зүйг дээшлүүлэх тал дээр анхаарал хандуулах, шат дараалсан төлөвлөгөөт арга хэмжээ зохион байгуулах санал боловсруулсан шат дараалсан арга хэмжээ авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагад үндэслэн тус хэлтсээс Хүүхдийн төлөө газартай хамтран хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж эхлэв.

Олон нийтэд чиглэсэн бас нэг арга хэмжээ нь дэлхийн шилдэг эрэн сурвалжлах сэтгүүлчдийн бэлтгэсэн авлигын нийгэмд үзүүлж байгаа хор хөнөөлийг таниулах зорилгоор бэлтгэсэн баримтат кинонуудыг эх хэлнээ хөрвүүлэн хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацаж байна. Энэ ажлын хүрээнд “Сичуань мужийн нулимс”, “Бидний мөнгө хаачив”, “Чишшшш, чимээгүй хэнд ч битгий хэлээрэй” гэсэн гурван киног эх хэлнээ орчуулан дуу мэргэжлийн дуу оруулагчидад дүрс, текстийг өгч дуу оруулах ажлыг гүйцэтгүүлсэн.

Авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ухуулан таниулах ажилд мэргэжлийн урлагийн байгууллагуудыг татан оролцуулах зорилгоор Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын Драм ангийн уран бүтээлчидтэй хамтран “Төлөөс” жүжгийг теле хэлбэрээр бүтээхэд продюсерийн үүрэгтэйгээр оролцлоо.

Төлөөс” жүжгийн дууны шүлгийг ажилтан Т.Мөнхтунгалаг зохиож, залуу уран бүтээлч П.Отгонцэнгэлээр ая зохиолгон, “Maggo” хамтлагаар дуулуулсан бөгөөд энэ нь Авлигатай тэмцэх газрын түүхэнд анхны удаа захиалж бүтээсэн дуу болсон.

Авлигын эсрэг олон улсын өдөр 12 дугаар сарын 9-ний өдрийг угтсан арга хэмжээг энэ оны хувьд харьцангуй эрт буюу буюу 6 сарын өмнөөс эхлүүлсэн. Энэ ажлын хүрээнд “Авлигаас ангид, сайн засаглалын туршлага-2013” улсын уралдааны удирдамжийг боловсруулж, өдөр тутмын “Өнөөдөр, “Өдрийн сонин”-д мэдээлсний зэрэгцээ байгууллагын цахим хуудсаар дамжуулан, Хэлтсийн ажилтнууд хариуцсан байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудтай холбогдож мэдээлэх замаар нийт төрийн байгууллагуудад хүргэх арга хэмжээг авч байна.

“Star санаачилга” байгууллагын Авлигатай тэмцэх газар, Хууль зүйн яам, Тагнуулын ерөнхий газар, Улсын Прокурорын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, МУИС-ийн Хууль зүйн сургууль, Хууль сахиулах их сургуулиудын багш ажилтнуудыг хамруулсан “Санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа”, “Эрх зүйн талаарх хамтын ажиллагаа” сэдэвт сургалтыг 5 дугаар сарын 6, 7, 9, 10-ны өдрүүдэд зохион байгуулж, сургалтын материалыг англи хэлнээс орчуулах, сургалт явуулах төсвийн төслийг боловсруулж ажилласан.

Авлигатай тэмцэх газар, “Мерси кор” олон улсын байгууллагатай хамтран “Шударга нийгмийн төлөө хамтдаа” аяныг зохион байгуулсан. Тус аян нь 2013 оны 9 дүгээр сарын 1-нээс 2013 оны 12 дугаар сарын 9-нийг хүртэл гурван сарын хугацаатай үргэлжилсэн бөгөөд хүүхэд залуусыг бага наснаас нь төлөвшүүлж, ёс зүйн боловсрол олгож, авлигыг үл тэвчих, шударга ёсыг эрхэмлэх үзэлтэй болгох нөлөөллийн ажлуудыг ажилтан Б.Тэрбиш, С.Галбадрах, Д.Балдандорж нар зохион байгуулж хариуцан ажилласан.

2013 онд авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр нэн тэргүүний зорилтоо авлигын шалтгаан, нөхцөлийг арилгахад чиглэсэн ажлыг эрчимжүүлэх, орон нутагт авлигын эсрэг хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр улам ойр ажиллаж арга зүйн зөвлөгөөгөөр тогтмол хангах, төрийн байгууллагуудын авлигын эсрэг үйл ажиллагааг илүү бодит үр дүнд хүрэхүйцээр төлөвлөхөд илүү анхаарах зэрэг асуудлууд гэж тодорхойлсон.

Чиг үүргийн дагуу төрийн байгууллагаас хэрэгжүүлж буй авлигын эсрэг үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор “Авлигын эсрэг үйл ажиллагааг үнэлэх аргачлал”-ыг боловсруулжээ.

Оюутанд олгох үндэсний тэтгэлэг 70200 төгрөгтэй холбоотой гомдол, мэдээлэл хэвлэл, мэдээллийн хэрэгслээр байнга гарч байсантай уялдуулж мэдээллийн мөрөөр энэхүү тэтгэлэгтэй холбоотой асуудлыг шалгах удирдамжийг Газрын даргаар батлуулан нийт 20 сургуулийг хамарсан хяналт, шалгалтын ажлыг Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс дангаар хийж гүйцэтгэсэн.

Хөдөө, орон нутгийн иргэд, олон нийттэй уулзаж, санал хүсэлтийг нь сонсох, төрийн болон төрийн өмчит байгууллагуудын авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, төрийн байгууллагуудын иргэдэд үйлчилгээ үзүүлэх хэсгүүдэд ажиллаж иргэдийн хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авах, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудыг сурталчлах зорилгоор 2013 оны 1 дүгээр сарын 3-наас 5 дугаар сарын 11-ний өдрийг хүртэл 20 аймагт ажилласан ба ажлын тайланд үндэслэн 20 аймаг тус бүрт Зөвлөмж хүргүүлсэн.

Нийслэлийн худалдан авах ажиллагааны газарт авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх зорилгоор 2013 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс 8 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд баталсан төлөвлөгөөний дагуу ажилласан.

Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар, Боловсролын газар, Эрүүл мэндийн газар, Өмчийн харилцааны газарт Азийн сан, Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2013-2014 онд хэрэгжүүлэх сайн засаглал, ил тод байдлыг бэхжүүлж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Хамтдаа” төслийн хүрээнд 11 ажил гүйцэтгээд байна.

2013 онд нийт 60 гаруй гомдол, мэдээллийг хүлээн авч холбогдох шалгалтын хийж дууссан байна. Үүнээс гадна хүлээн авч зохих шалгалтыг явуулж байгаа гомдол, мэдээллийн нэгдсэн мэдээллийн сантай болох зорилгоор гомдол мэдээллийн нэгдсэн цахим бүртгэлийг суулгуулан 67 гомдол, мэдээллийн шаардлагатай мэдээллүүдийг шийдвэрлэлтийн хамт бүртгээд байна. Цахим бүртгэлтэй болсноор бид хүлээн авч шалгаж шийдвэрлэсэн гомдол, мэдээллүүдийн холбогдох мэдээг хугацаа алдалгүй гаргах боломжтой болсон юм.

“Нийслэл, дүүргийн өмч газрын харилцааны албадын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулан хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 4 ажлыг хийж гүйцэтгэж байна.

Бид 2014 онд урьдчилан сэргийлэх чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг илүү бодлогын түвшинд уялдуулан хэрэгжүүлэх, зохион байгуулалтыг сайн хийх Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн стратеги төлөвлөгөөг гаргах, иргэдийг хамгийн их бухимдуулж, хүндрэл, чирэгдэл учруулдаг салбарууд руу чиглэсэн үйл ажиллагааг эрчимжүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг илүү цэгцтэй бодлогын хүрээнд явуулах зэрэг зорилт тавьж байна.

Авлигын индексийн 2013 оны судалгааны ажлыг үндсэн 2 үе шаттай 3 чиглэлээр зохион байгуулав. Судалгааны эхний үе шатанд холбогдох байгууллага, албан тушаалтнуудтай хамтран ажиллаж, ажлын уялдаа холбоог ханган, судалгааны түүвэр гаргах, судалгааны маягт, заавар, гарын авлага боловсруулах, хэвлүүлэх, ярилцлага авагч нарт сургалт зохион байгуулах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэв. Судалгааны үндсэн үе шатанд асуулгыг түгээх, цуглуулсан мэдээллийг CSPPro программд оруулан SPSS программ дээр тооцоолон, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан эрүүгийн гэмт хэргийн хүрээнд баримтын судалгаа хийж, индексийг гаргах ажлыг зохион байгуулав.

Монгол Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолд зааснаар “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаархи төсөөлөл”-ийн үзүүлэлтийг Судалгаа шинжилгээний алба 5 дахь удаагаа тооцон гаргах ажлын хүрээнд цуглуулсан мэдээллийг программд оруулан, холбогдох тооцооллыг хийж, үр дүнг гарган олон нийтэд мэдээлсэн болно.

Хүүхдийн шударга байдлын 2013 оны судалгааг Хүүхдийн төлөө үндэсний газартай хамтран аймаг, нийслэлийн 800 хүүхдийг хамруулан зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэв.

**Гурав. Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон  
хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт,  
хяналт шалгалтын чиглэлээр**

Тайлант хугацаанд Авлигатай тэмцэх газарт хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлбэл зохих 278 төрийн өндөр болон түүнтэй

адилтгах албан тушаалтны мэдүүлгийг цаасан хэлбэрээр болон цахим хэлбэрээр хуулийн хугацаанд 100 хувь хүлээн авч бүртгэн, нууцлалыг ханган хадгалж байна.

Авлигатай тэмцэх газарт мэдүүлгээ бүртгүүлдэг албан тушаалтнуудын мэдүүлгийг “Төрийн мэдээлэл” эмхтгэлд нийтлүүлэх ажлыг Авлигын эсрэг хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан хугацаанд зохион байгуулж **239** төрийн өндөр албан тушаалтан болон тэдгээртэй адилтгах албан тушаалтны 2012 оны мэдүүлгийг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлүүлсэн болон тус газрын Олон нийтийн вэб сайт [www.xacxom.iaac.mn/](http://www.xacxom.iaac.mn/)-д байршуулж иргэд, олон нийтэд нээлттэй болгосон.

Тайлангийн хугацаанд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны 111 байгууллагын мэдүүлгийн бүрдүүлэлтийн 2013 оны тайлан мэдээг цаасаар болон цахим хэлбэрээр гаргуулан авч нэгтгэсэн. Улсын хэмжээнд 47142 мэдүүлэг гаргагч бүртгэгдсэнээс 47127 мэдүүлэг гаргагч буюу 99,97 хувь нь бүртгүүлсэн. Үүнээс 47105 мэдүүлэг гаргагч хуульд заасан хугацаандаа мэдүүлгээ бүртгүүлсэн, 22 мэдүүлэг гаргагч хугацаа хожимдуулж, 15 мэдүүлэг гаргагч мэдүүлгээ огт гаргаж өгөөгүй байна.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн тайлангаар зөрчил гаргасан дээрх **37** албан тушаалтнаас ИТХ-ын төлөөлөгчөөс чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан зэрэг шалтгааны улмаас **2** мэдүүлэг гаргагчид хариуцлага тооцох боломжгүй байсан. **31** албан тушаалтанд сануулах, **2** албан тушаалтанд ажлаас халах сахилгын арга хэмжээг тус тус авахуулсан байна.

Авлигатай тэмцэх газрын **149** албан хаагчийн хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг цаасан хэлбэрээр болон цахимаар хуульд заасан хугацаанд бүртгэж авсан. Мөн тус газарт **83** албан тушаалтан их хэмжээний өөрчлөлтөө хуульд заасан хугацаанд мэдүүлгээ цаасаар болон цахим хэлбэрээр мэдүүлснийг тус тус бүртгэсэн. Мөн Авлигатай тэмцэх газарт Худалдан авах үйл ажиллагаа /тендер/ болон хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулахад **45** “Ашиг сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн, зөрчил үүссэн тухай мэдэгдэл” маягтыг гаргасныг бүртгэж авсан.

Аймаг, сум, дүүргийн ИТХ-ын 2012 оны сонгуульд нэр дэвшиж сонгогдсон 242 ширхэг архивын нэгж бүхий **6875** төлөөлөгчийн, 2013 онд нөхөн сонгуульд нэр дэвшин сонгогдсон аймаг, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчөөр нөхөн сонгогдсон ИТХ-ын **15** төлөөлөгчийн, Улсын Их Хурлын гишүүнээр 2012, 2013 онд шинээр сонгогдсон **5**, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч Ц.Элбэгдорж нарын “Сонгуульд нэр дэвшигчийн хөрөнгө, орлогын

мэдүүлэг”-ийг Сонгуулийн ерөнхий хорооноос гаргуулан авах ажлыг зохион байгуулж ажилласан.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах ажлын хүрээнд Мэдүүлгийн бүрдүүлэлт, дүн шинжилгээний албаны 2013 онд хийх мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтын төлөвлөгөөг Хэлтсийн даргаар батлуулсан ба энэ онд 2000 орчим мэдүүлэг гаргагчыг хамруулсан төрийн төв 7 байгууллага, түүний салбар нэгжүүдэд мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналт шалгалтыг хийхээр төлөвлөн ажилласан.

Энэхүү төлөвлөгөөт хяналт шалгалтын ажлын хүрээнд энэ онд Үндэсний Аудитын газар, Нийслэлийн Аудитын газар, Улаанбаатар хотын хүрээнд байршилтай төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой 47 аж ахуйн нэгж, Эрүүл мэндийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Соёл, спорт, аялал жуулчлалын яам, Эдийн засгийн хөгжлийн яам, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар болон харьяа Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Банк, хадгаламж зээлийн хоршоодын төлбөр барагдуулах алба, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын харьяа 7 агентлаг зэрэг байгууллагуудад хийгдэх бүрдүүлэлтийн хяналт шалгалтын удирдамжийг боловсруулж, Газрын даргаар батлуулан хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдсан байгууллагууд болон орон нутагт хийгдсэн мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаар гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах, хариуцлага тооцуулах, холбогдох арга хэмжээг авахуулж зөвлөмж хүргүүлэх тухай **71** /давхардсан тоогоор/ байгууллагын удирдах албан тушаалтанд албан бичиг хүргүүлсэн.

“Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд зориулсан гарын авлага”, “Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагчид зориулсан гарын авлага”-ыг бэлтгэн боловсруулж тус бүр **3000** хувийг хэвлүүлэн байгууллагуудад хүргүүлэн зөвлөмж өгч ажилласан.

Мэдүүлгийн бүрдүүлэлтийн чиглэлээр 2013 онд давхардсан тоогоор **200** орчим байгууллагын **1423** эрх бүхий албан тушаалтан, **9557** мэдүүлэг гаргагч, нийт **10980** албан тушаалтныг хамруулсан сургалтыг зохион байгуулж ажилласан.

Хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгээ цахимаар хэрхэн мэдүүлэх тухай болон хуулийн хугацааг сануулсан баннер сурталчилгааг “Өдрийн

сонин”, “Өнөөдөр сонин”, “Үндэсний шуудан”, “Нийгмийн толь”, “Ардчилал” зэрэг өдөр тутмын сонинд, мөн [www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.news.mn](http://www.news.mn), [www.oloo.mn](http://www.oloo.mn) сайтад, мөн хуулийн хугацаа сануулсан, цахим бүрдүүлэлтийг сурталчилсан видео сурталчилгааг Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр, Ийгл, SBN, 25 дугаар суваг зэрэг телевизээр 2013 оны 02 дугаар сарын 15-ныг дуустал нэвтрүүлсэн бөгөөд сурталчилгааны цацалтанд хяналт тавьж ажилласан.

Мөн бүрдүүлэлтийн явц байдал, цахимаар мэдүүлгээ мэдүүлэх талаарх зөвлөмжийг “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Үндэсний шуудан”, “Зууны мэдээ”, “Өдрийн шуудан”, “Монголын мэдээ”, “Улс төрийн тойм”, “Өглөөний сонин”, “Ардчилал”, “Улаанбаатар таймс”, “Нийгмийн толь” зэрэг өдөр тутмын сонин болон [www.gogo.mn](http://www.gogo.mn), [www.news.mn](http://www.news.mn), [www.oloo.mn](http://www.oloo.mn) сайт зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2013 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн дугаарт гаргаж, олон нийтэд мэдээллийг хүргэсэн.

Нутгийн удирдлагын холбоотой хамтран аймаг, сумын ИТХ-ын ажлын алба, Засаг даргын Тамгын газрын ажилтнуудад хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн талаар сургалтыг зохион байгуулсан. Цаашид энэ ажлыг хэрэгжүүлж ажилласнаар аймаг, сумын Засаг даргын Тамгын газар болон ИТХ-ын Ажлын албаны ажилтнууд, төлөөлөгч нарт хүрч ажиллах боломжтой болсон.

Албан тушаалтнууд Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгээ цахимаар хэрхэн мэдүүлэх тухай болон хуулийн хугацааг сануулсан /баннер/ сурталчилгааг өдөр тутмын 5 сонин, 4 сайт, мөн хуулийн хугацааг сануулсан, цахим бүрдүүлэлтийг сурталчилсан видео сурталчилгааг Монголын Үндэсний Олон нийтийн телевизийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр, Ийгл ТВ, SBN, 25 дугаар суваг зэрэг телевизээр 2013 оны 2 дугаар сарын 15-ныг дуустал нэвтрүүлсэн бөгөөд сурталчилгааны цацалтанд хяналт тавьж ажилласан.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт, түүний явц байдал, цахим бүрдүүлэлт, тайлан мэдээний дүнгийн талаар 13 телевизид 16 удаа, 11 өдөр тутмын сонинд, 3 сайтад болон өөрийн байгууллагын цахим хуудсаар мэдээллийг олон нийтэд хүргэж ажилласан.

Хяналт шалгалтын ажлын хүрээнд 2013 онд нийт 557 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгахаар хүлээн авснаас 533-ийг шалгаж дууссан бөгөөд 24 албан тушаалтны мэдүүлгийг шалгах ажил үргэлжилж байна.

Мэдүүлгийн хяналт шалгалтаар гарсан үр дүнгээр мэдүүлгийг нь шалгаж дууссан нийт **533** албан тушаалтнаас **52,2** хувь буюу **278** нь зөрчилгүй, **24,4** хувь буюу **130** нь хөрөнгө, орлогоо худал мэдүүлсэн, **15,2** хувь буюу **81** нь зөрчилтэй мэдүүлсэн боловч хариуцлага тооцуулах хэмжээнд хүрээгүй, **8,2** хувь нь буюу **44** нь хуулийн үйлчлэлд хамаарахгүй болсон байна.

Нийт мэдүүлгийн **363** нь төлөвлөгөөт хяналт шалгалтаар, **98** нь иргэд, байгууллагын гомдол, мэдээллээр, **96** нь тус газрын Мөрдөн шалгах хэлтсийн хүсэлтээр тус тус шалгуулахаар бүртгэгдсэн байна.

“Шударга нийгмийн төлөө хамтдаа” аяны хүрээнд Нийслэлийн Засаг даргын дэргэдэх 7 агентлаг /Нийслэлийн Ерөнхий төлөвлөгөөний газар, Худалдан авах ажиллагааны газар, Нийтийн тээврийн газар, Авто замын газар, Эрүүл мэндийн газар, Нийслэлийн өмчийн харилцааны газар, Нийслэлийн Боловсролын газар/-ийн нийт 420 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүрдүүлэлтийн шалгалтыг хийж, давхардсан тоогоор 123 зөрчлийг илрүүлж, 106 албан тушаалтны мэдүүлгийг нарийвчлан шалгасан.

Хяналт шалгалтын чиглэлээр 2013 оны тайлант хугацаанд иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас ирүүлсэн нийт 311 өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авсан байна.

Нийт 311 өргөдөл, гомдол, мэдээллээс 282 өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэсэн, одоо 29 өргөдөл, гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй. Хянан шийдвэрлэсэн өргөдөл, гомдлоос 189 буюу 67,2 хувийг хуулийн хугацаанд буюу 30 хоногт, 93 буюу 32,8 хувийг хугацаа сунгаж хянан шийдвэрлэсэн бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 114-өөр нэмэгдсэн буюу 1,1 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Хүлээн авсан нийт гомдол, мэдээллийн 216 буюу 69,4 хувийг хувь хүн, иргэнээс, 48 буюу 15,4 хувийг төрийн байгууллага, төрийн өмчит компани, аж ахуйн нэгжээс, 29 буюу 9,3 хувийг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд, 18 буюу 5,7 хувийг нэргүй мэдээлэл эзэлж байна.

Хянан шийдвэрлэсэн 282 өргөдөл, гомдол, мэдээллийг зөрчлөөр нь авч үзвэл,

- Албан тушаалтны буруутай үйл ажиллагааг илрүүлж, хариуцлага тооцуулахаар шийдвэрлэсэн 45 буюу 15,9 хувийг,



- Зөрчлийг арилгуулахаар эрх бүхий байгууллага албан тушаалтанд хандаж шийдвэрлүүлсэн 48 буюу 17,2 хувийг,
- Хууль бус шийдвэрийг хүчингүй болгох, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар анхааруулсан буюу шаардлага хүргүүлсэн 51 буюу 18,1 хувийг,
- Гомдолд дурьдсан асуудал нь тогтоогдоогүй буюу зөрчил илрээгүй 53 буюу 18,7 хувийг,
- Гэмт хэргийн шинжтэй зөрчлийг шалгуулахаар Мөрдөн шалгах хэлтэс болон Цагдаагийн байгууллагад харъяаллын дагуу шилжүүлсэн 26 буюу 9,2 хувийг,
- Төрийн байгууллагад харъяаллын дагуу шилжүүлсэн 47 буюу 16,6 хувийг,
- Хуульд заасан үндэслэлээр буцаасан 12 буюу 4,2 хувийг тус тус эзэлж байна.

Өргөдөл, гомдол, мэдээллийг агуулгын хэлбэрээр нь авч үзвэл албаны эрх мэдлээ урвуулсан, хэтрүүлсэн, бусдад давуу байдал олгосон талаар 79 буюу 23,2 хувийг, хууль тогтоомж зөрчсөн, хууль бус үйлдэл гаргасан талаар 64 буюу 20,5 хувийг, албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, сонирхлын зөрчилтэй шийдвэр гаргасан талаар 95 буюу 30,5 хувийг, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгуулах болон үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн талаар 48 буюу 15.4 хувийг, бусад 25 буюу 8,3 хувийг тус тус эзэлж байна.

Мөн нийт 311 өргөдөл, гомдол, мэдээллээс 151 нь буюу 48,5 хувийг орон нутаг дахь байгууллага албан тушаалтантай холбоотой өргөдөл, гомдол эзэлсэн байна.

Хөдөө, орон нутгаас ирүүлсэн гомдол, мэдээллийг албан томилолтоор ажиллаж, газар дээр нь шалгах ажлыг сүүлийн улиралд эрчимжүүлж ажилласан.

2013 оны тайлант хугацаанд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 10490 этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хүлээн авснаас 10338 этгээдийн урьдчилсан мэдүүлгийг хянан шийдвэрлэж холбогдох байгууллагад хариуг хүргүүлсэн, 152 мэдүүлэг хянагдаж байна.

Хянан шийдвэрлэсэн урьдчилсан мэдүүлгийг өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 7282-оор нэмэгдсэн буюу 3,1 дахин нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Тус

газарт ирүүлсэн урьдчилсан мэдүүлгийн 40-41 хувийг хөдөө, орон нутгаас ирүүлсэн мэдүүлэг эзэлж байна.

Хянан шалгасан урьдчилсан мэдүүлгийг хүснэгтээр харуулбал:

|                         |                            |                                      |                                   |  |   |   |          |
|-------------------------|----------------------------|--------------------------------------|-----------------------------------|--|---|---|----------|
| Нийт хүлээн авсан ХАСУМ | Хянан шийдвэр--лэсэн ХАСУМ | АСЗ үсэх нөхцөл байдал тогтоогдоогүй | АСЗ үсэх нөхцөл байдлыг сануулсан | АСЗ үсэх нөхцөл байдлыг тогтоож анхааруулсан | Илт ашиг сонирхлын зөрчил үсэх нөхцөл байдал бий болсон | Хууль, журамд заасан үндэслэлээр буцаасан | Үлдэгдэл |
| 10490                   | 10338                      | 2546                                 | 3160                              | 2800   | 52  | 1780                                      | 152      |

Мөн албан тушаалтны урьдчилсан мэдүүлгийг тус газраар хянуулахгүйгээр хууль зөрчин томилсон 320 гаруй этгээдийн тушаал, шийдвэрийг хүчингүй болгож, шийдвэрлэсэн байна.

Хяналт шалгалтын үр дүнгээр зөрчил гаргасан нийт 89 нь буюу 35 хувь нь орон нутаг дахь байгууллагын, 166 нь буюу 65 хувь нь Улаанбаатар хот дахь байгууллагуудын, нийт 255 албан тушаалтанд 43 хувь буюу 110-т нь ХАСХОМ-ийн, 18 хувь буюу 45-т нь өргөдөл, гомдлын, 39 хувь буюу 100-д нь мэдүүлгийн бүрдүүлэлтийн хяналтаар тус тус хариуцлага тооцуулсан байна.

Хариуцлага тооцуулсан нийт 255 албан тушаалтны 26 нь ажлаас халсан, 22 нь албан тушаал бууруулсан, 94 нь албан тушаалын цалинг 3 хүртэл сарын хугацаанд 30 хувиар бууруулсан, 95 нь сануулсан, 18 нь бусад арга хэмжээ гэсэн тоон үзүүлэлттэй байна.

### **Дөрөв. Авлигын гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах чиглэлээр**

Тайлангийн хугацаанд хуульд заасан харьяаллын 499 үйлдэлтэй 187 эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан нь 2012 оны мөн үетэй харьцуулахад 12.7 хувиар өссөн байна.

Мөрдөн байцаалт явуулсан нийт хэрэг, үйлдлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсгээр ангилбал

- төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах 70 буюу 26.4 хувь,
- төрийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 25 буюу 9.4 хувь,
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах 19 буюу 7.2 хувь,
- төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ хэтрүүлэх 1 буюу 0.4 хувь,
- хээл хахууль авах 22 буюу 8.3 хувь,
- хээл хахууль өгөх 20 буюу 7.5 хувь,
- хээл хахуульд зуучлах 8 буюу 3 хувь,
- төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах 6 буюу 2.2 хувь,
- хууль бусаар хөрөнгөжих 1 буюу 0.4 хувь,
- бусад 93 буюу 35.2 хувийг эзэлж байна.

Мөрдөн шалгасан эрүүгийн хэргийн шийдвэрлэлтийг авч үзвэл 43 хэргийг буюу нийт шалгасан хэргийн 22.9 хувийг яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 23.2 хувиар өссөн, 41 хэргийг буюу 21.9 хувийг хэрэгсэхгүй болгох саналтайгаар шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 19.5 хувиар өссөн, 30 хэргийг буюу 16 хувийг харьяаллын дагуу шилжүүлсэн нь өмнөх онтой харьцуулахад 16.7 хувиар өссөн, 21 хэргийг буюу 11.2 хувийг өөр эрүүгийн хэрэгт нэгтгэж, 13 хэргийг мөрдөн байцаалтын ажиллагааг түдгэлзүүлсэн байна.

Тайлант хугацааны эцэст ажиллагаанд 39 эрүүгийн хэргийн үлдэгдэлтэй байна.

Эрүүгийн хэрэгт нийт 400 хүн сэжигтэн, яллагдагчаар татагдан шалгагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 36.5 хувиар өссөн байх бөгөөд холбогдогчдыг албан тушаалын байдлаар авч үзвэл төрийн улс төрийн 35 буюу 8.7 хувь, төрийн захиргааны албан хаагч 85 буюу 21.2 хувь, төрийн тусгай албан хаагч 46 буюу 11.5

хувь, төрийн үйлчилгээний албан хаагч 42 буюу 10.5 хувь, энгийн буюу аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан 192 буюу 48 хувь байна.

Яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн хэргээс 33 шүүгдэгчид холбогдох 11 хэрэг шүүхээр шийдвэрлэгдэж, 26 шүүгдэгчийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон 12 шүүгдэгчийг хорих ялаар, 5 шүүгдэгчийг торгох ялаар, 1 шүүгдэгчийг баривчлах ялаар, 2 шүүгдэгчийг тодорхой ажил, албан тушаал эрхлэх эрхийг хасах нэмэгдэл ялаар шийтгэж хорих ял оногдуулсан 8 шүүгдэгчийн ялыг тэнссэн. Мөн 7 шүүгдэгчид холбогдох 2 хэргийг хэрэгсэхгүй болгож шүүгдэгч нарыг цагаатгасан байна.

Мөрдөн шалгасан нийт эрүүгийн хэрэгт 85 тэрбум төгрөгийн хохирол учирсан нь өмнөх оноос 44.7 хувиар өссөн, 6.3 тэрбум төгрөгийн хохирлыг мөрдөн байцаалтын явцад нөхөн төлүүлсэн нь өмнөх оноос 50.7 хувиар, 17.1 тэрбум төгрөгийн эд зүйлийг битүүмжлэн хамгаалсан нь өмнөх оноос 77.1 хувиар тус тус өссөн байна.

Тайлангийн хугацаанд Авлигатай тэмцэх газарт нийт 970 гомдол, мэдээлэл хүлээн авсныг “Гомдол, мэдээллийн нэгдсэн бүртгэл”-д бүртгэснээс гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 422 бүртгэгдсэн нь 2012 онтой 18.2 хувиар өссөн байна.

Урьд оны үлдэгдэл 5 гомдол, мэдээлэл, шинээр хүлээн авсан 422 нийт 427 гомдол, мэдээллийг хянан үзсэнээс 58 гомдол, мэдээлэл буюу 13.5 хувьд эрүүгийн хэрэг үүсгэсэн нь өмнөх онтой харьцуулахад 20.5 хувиар буурсан, 176 гомдол, мэдээлэл буюу 41.2 хувьд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал гаргасан нь өмнөх онтой харьцуулахад 17 хувиар өссөн, 152 гомдол, мэдээлэл буюу 35.6 хувийг харьяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн нь өмнөх онтой харьцуулахад 18.4 хувиар өссөн байна. Эрүүгийн хэрэг болон гомдол мэдээлэлд 6-г нэгтгэн шалгаж, ажиллагаанд 35 гомдол, мэдээллийн үлдэгдэлтэй, шийдвэрлэлт 91.7 хувьтай байна.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол, мэдээллийн агуулга, холбогдох байгууллага, салбараар авч үзвэл нутгийн захиргааны болон өөрөө удирдах байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 103 /үүнээс 68 нь Засаг даргын үйл ажиллагаанд, 35 нь Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд/, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хамаарах 72 / үүнээс 17 нь цагдаа, 6 прокурор, 6 нь шүүх, 12 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, 6 нь мэргэжлийн хяналт, 11 нь гааль, 7 нь татвар, 5 нь онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага, 2 нь тагнуул/, боловсрол, эрүүл мэнд, төрийн үйлчилгээний салбарт хамаарах 58 /үүнээс 27 нь боловсрол, 25 нь эмнэлэг, 6 нь улсын бүртгэлийн албанд/, газар, ашигт малтмалын

салбарт хамаарах 23, яамдын үйл ажиллагаатай холбоотой 23, УИХ-ын гишүүнд холбоотой 4, төрийн болон орон нутгийн өмчит улсын үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хамаарах 51, банк санхүүгийн салбарт хамаарах 7, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хамаарах /хувийн хэвшил/ 40, бусад байгууллагад хамаарах 46 тус тус эзэлсэн байна.

Эдгээр гомдол, мэдээллийг хүлээн авсан хэлбэрээр нь ангилбал бичгээр 332, утсаар 16, шуудангаар 47, интернэтээр 2, биечлэн 29, факсаар 1 гомдол, мэдээлэл иржээ.

Хүлээн авч, хянан үзсэн гэмт хэргийн шинжтэй гомдол мэдээлэл, мөрдөн шалгасан эрүүгийн хэрэг, яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлсэн эрүүгийн хэрэг, эрүүгийн хэрэгт холбогдогсод болон гэмт хэргийн улмаас учирсан хохирол, түүний нөхөн төлүүлэлт 2012 онтой харьцуулахад өссөн байна.

## ДҮГНЭЛТ

Авлигатай тэмцэх газрын хэлтэс албадын 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлын тайланг нэгтгэхэд Авлигын эсрэг хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ Авлигатай тэмцэх газар зохих ёсоор гүйцэтгэсэн байна гэж дүгнэх боломжтой байна.

Тайлангаас харахад үйл ажиллагаагаа өмнөх онтой харьцуулахад идэвхжсэн байгаа нь орон тоо нэмэгдэж ажилтан албан хаагчид ажлын байрны давхардал багасч тус тусын ажлын байрны тодорхойлолтод заагдсан ажлыг хэрэгжүүлэх боломжтой болсонтой тодорхой хэмжээгээр холбоотой гэж үзэж байна

Өмнө оны мөн үетэй харьцуулан үзэхэд хүлээн авч шалгасан гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 48-аар өссөн дүнтэй гарч байгаа нь иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тус хэлтэст хандсан гомдол, мэдээллийн урсгал нэмэгдсэн, байгууллагын үйл ажиллагаанд итгэл үзүүлсэн, асуудлыг гагцхүү Авлигатай тэмцэх газраар шалгаж шийдвэрлүүлэх хүсэлтэй байгааг харуулж байна.

Энд зөвхөн гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийг дурдах бус Авлигатай тэмцэх газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн бүхий л төрлийн гомдол мэдээллийг өмнөх оныхтой харьцуулан үзэхэд 2012 онд нийт 398 гомдол нэгдсэн бүртгэлд бүртгэж байсан бол 2013 онд 663 гомдол, мэдээлэл болж даруй 66,5 хувиар өссөн нь тус газрын ажлын хэсэг нийт аймагт ажилласантай шууд холбоотой гэж үзэхээр байна.

Мөн тодорхой хэргүүдэд мөрдөн байцаагч нарын ажлын хэсэг байгуулан ажиллуулснаар, тухайн ажлын хэсгээр шалгаж байгаа хэрэг ажиллагаа ихтэй, өргөн

цар хүрээг хамарч байгаагаас хамааран мөрдөн байцаагч нар бусад эрүүгийн хэрэгт мөрдөн байцаалтын хангалттай ажиллагааг шуурхай явуулж чадахгүй байх, ачаалал хөнгөвчлөх зорилгоор зарим хэргийг өөр мөрдөн байцаагчид шилжүүлснээр ажлын хэсэгт ороогүй мөрдөн байцаагч нарын гар дээрх гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийн ачаалал нэмэгдсэн зэрэг нь гомдол, мэдээлэл, эрүүгийн хэргийг богино хугацаанд бүрэн гүйцэд шалгахад сөргөөр нөлөөлсөн байж болзошгүй байна.

## **АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР**